

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<p><b>Эцэг/эхийн нэр:</b> Жамсран <b>Ургийн овог:</b> Тайжууд <b>Нэр:</b> Гэрэлмаа <b>Хүйс:</b> эм <b>Төрсөн он:</b> 1986 <b>Төрсөн газар:</b> Ховд аймаг, Цэцэг сум <b>Иргэний харьяалал:</b> Монгол улс <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг</p> <p><i>/Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i></p>	
1.2	<p><b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b></p> <p>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн</p>	
1.3	<p><b>Нэр дэвшүүлсэн албан байгууллага</b> Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо</p>	
1.4	<p><b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <ul style="list-style-type: none"><li>• Австрали улс, Сидней хот, Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургууль, Эрүүл мэндийн удирдлагын ухааны магистр, 2017.01- 2018.08 сар</li><li>• Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль, орчуулагч, бакалавр, 2006 - 2008 он</li><li>• Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургууль, Нийгмийн Эрүүл мэндийн сургууль, Эрүүл мэндийн эдийн засагч, бакалавр, 2003 – 2007 он</li><li>• Ховд аймгийн 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, Бүрэн дунд боловсрол, 1994 - 2003</li></ul>	
1.5	<p><b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"><li>• ДЭМБ-ын Эрүүл мэндийн санхүүжилтийн бодлогын зөвлөх, 2022.07 – одоог хүртэл</li><li>• АХБ-ны Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах ТТ-9701 төсөл, Тусламж, үйлчилгээний багц хариуцсан зөвлөх, 2020.01 – 2022.05</li></ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>• НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан зөвлөх, 2018.10 – 2020.01</li> <li>• Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, 2011.06 – 2016.09</li> <li>• Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хэлтсийн дарга, хяналт үнэлгээний мэргэжилтэн - 2009.03 – 2011.05</li> <li>• Нийслэлийн Эрүүл мэндийн газар, эдийн засагч, 2007.10 - 2009.03</li> </ul>
1.6	<p><b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих.</p> <p><b>Үгүй</b></p>
1.7	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/ <b>Үгүй</b></p>
1.8	<p><b>Яллагдагчаар татагдсан эсэх</b> Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/. <b>Үгүй</b></p>
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <b>Үгүй</b></p>
1.10	<p><b>Төрийн бус байгууллагагын гишүүнчлэлийн талаар</b> -Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ. Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо, удирдах зөвлөлийн гишүүн, 2012 оноос хойш</p>
1.11	<p><b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p>

<p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>
<p><b>Ном, тайлан, шийдвэр, зөвлөмж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга” техникийн тайлан, 2022 он, төслийн багийн гишүүдийн хамт боловсруулсан.</li> <li>• Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Стратегийн худалдан авалтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, аргачлалын эмхэтгэл, 2022 он, төслийн багийн гишүүдийн хамт боловсруулсан.</li> <li>• Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтын гарын авлага, 2022 он, төслийн багийн гишүүдийн хамт боловсруулсан.</li> <li>• “Эрүүл мэндийн төлбөрийн аргын тогтолцоог хянахад дата, дүн шинжилгээг ашиглах нь: Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхээр зорьж буй орнуудад зориулсан гарын авлага” JLN, 2017 он, гарын авлагыг боловсруулахад хувь нэмрээ оруулсан.</li> <li>• Монгол улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөрийн системийн үнэлгээ, 2017</li> </ul> <p><b>Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2015 он</li> <li>• Эрүүл мэндийн даатгалын урт хугацааны бодлогын баримт бичиг</li> <li>• ЭМС, СС, НХХСайдын хамтарсан эрүүл мэндийн даатгалтай холбогдох тушаал, журмууд 2012-2016</li> <li>• Монгол улсын Засгийн газрын 2012 оны 150, 151, 152 дугаар тогтоол</li> </ul>

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

<p><b>2.1</b></p>	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p><b>Нэр дэвшсэн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup>.2.3-т заасны дагуу Үндэсний зөвлөлд ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлсөн гурван хүн томилогддог. Монголын Ажил олгогч Эдийн Нэгдсэн холбоо нь 1990 онд байгуулагдсанаас хойш 21 аймагт салбартай, 41 мэргэжлийн холбоодтой, нийт 8100 гишүүн дэмжигчидтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хуулийн дагуу ажил олгогчийг төлөөлөх зөвлөлийн гишүүнээр Ж.Гэрэлмааг нэр дэвшүүлж байна.</li> <li>• Олон улсад Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд ажил олгогч, даатгуулагч, төрийн төлөөллөөс гадна тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болох эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын эрх ашгийг төлөөлөх гишүүд багтдаг бөгөөд Монгол улсын Эрүүл мэндийн даатгалын хуулиар уг тал ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнд байхгүй хэдий ч Монголын ажил олгогч Эдийн Нэгдсэн холбооноос Сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбооны төлөөллийг 1) Нийт ажил олгогчийг эрх ашгийг төлөөлөх 2) Эрүүл мэндийн байгууллагуудын эрх ашгийг төлөөлүүлэхээр нэр дэвшүүлсэн.</li> <li>• ЭМДҮЗ нь эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгалын ирээдүйн хөгжил болон хүн амыг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс</li> </ul>
-------------------	---

хамгаалахад чухал нөлөө бүхий шийдвэрүүдийг гаргадаг тул эрүүл мэндийн бодлого, удирдлага, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэргэшиж буй туршлага, чадамжийг нь үнэлэн нэр дэвшүүлж байна.

**Томилогдвол хийх ажил:**

ЭМДҮЗ-ийн гишүүн нь бие даан үйл ажиллагаа явуулах, бие даан шийдвэр гаргах эрхгүй, гишүүдийн хамтын, дийлэнхи олонхийн шийдвэрээр шийдвэр гаргадаг. Миний бие ЭМДҮЗ-ийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1-т заасан ЭМДҮЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараах байр суурийг баримтлан ажиллана.

- Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг аль болох үр ашигтай, иргэн, даатгуулагчид ээлтэй байх зарцуулах байр суурьтайгаар ажиллана.
- Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрыг Стратегийн худалдан авагч болсон тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Иргэн, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг дэмжиж ажиллана.
- ЭМДҮЗ-ийн шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан, ил тод байхад анхаарч ажиллана.

**Хавсралт:**

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

-Төрийн албан хаагчийн анкет;

-Боловсролын зэргийн дипломын хуулбар;

-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

-Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Жамсран

Өөрийн нэр: Гэрэлмаа

Гарын үсэг:



Он, сар, өдөр: 2023 оны 3 дугаар сарын 16

--- оОо ---